



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 412

Улаанбаатар хот

Б.Баттулгыг ажилд томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 01/6369 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2019 оны 05/8641 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан Багдайн Баттулгыг “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Баттулгатай контрактын гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 221 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хууль зүйн хэлтэс (А.Ариунболд)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



000090?